

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Цагаан эрэг тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/008/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Албан шаардлага	14
5.2 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ЦАГААН ЭРЭГ ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.ЦЭЛМЭГ ТАНАА

2025.03.14 № 028-2025/008/НА-СТА-ОНӨТҮГ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар болон санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд илэрсэн дараах зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, ХХОАТ-ын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, ТБОНӨХБАУХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1, 2, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны

бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тус газрын 2024 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй,
- Өмнөх аудитаар өгөгдсөн насжилт өндөртэй авлагын үлдэгдэлд дүн шинжилгээ хийж, авлагыг барагдуулах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагуудад хандаж шийдвэрлүүлэх, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал: өмнөх оны аудитуудаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй буюу тус байгууллагын захирлаар ажиллаж байсан Д.Ганцэцэгт холбогдох 2,115.6 мянган төгрөгийн, И.Чулуунболдод холбогдох 8,049.0 мянган төгрөгийн зэрэг нийт **10,164,6** мянган төгрөгийн төлбөрийг өнөөг хүртэл барагдуулалгүйгээр авлагаар тайлагнасан,
- Ажилчдын цалингаас суутгасан 5,644.1 мянган төгрөгийн НДШ-ийн, 6,142.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын зэрэг нийт **11,786.7** мянган төгрөгийг холбогдох дансад шилжүүлэлгүйгээр гудамж талбайн цэвэрлэгээ үйлчилгээний давс худалдан авахад зориулалт бусаар зарцуулсан,
- Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээнд бэлтгэн нийлүүлэх бараа материалын нэр, тоо ширхэг, үнэ, нийлүүлэх хугацаа, төлбөрийн нөхцөл, нийлүүлэгчийн гарын үсэг зэрэг үзүүлэлтийг тодорхой тусгаагүй, худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зэргээр анхан шатны бүрдэл дутуу баримтаар **41,585.0** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- Шууд худалдан авах болон харьцуулалтын аргын босго үнээс давсан 157,019.5 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бус гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь тайлант онд 1,121,679.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,598,893.1 мянган төгрөгийн зардал гарган 477,213.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдал нь үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр бус үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас голлон шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Сүхбаатар сумын төсвийн санхүүжилтээр 1,100,000.0 мянган төгрөг, ЗДНХ-өөс 1,500.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 20,179.7 мянган төгрөг зэрэг нийт 1,121,679.7 мянган төгрөг төвлөрүүлэн, 1,598,893.1 мянган төгрөгийн зардал гарган, 477,213.4 мянган төгрөгийн алдагдал хүлээж өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны үйл ажиллагааны явцын тайланг хэлэлцээд Сүхбаатар сумын ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 10 дугаар тоот тогтоолоор “хангалттай” гэж үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,221,510.87	1,019,918.42
1.1.2.	Дансны авлага	19,976,453.00	20,061,573.05
1.1.5.	Дуусаагүй үйлдвэрлэл	28,850,000.00	28,850,000.00
1.1.6.	Бараа материал	72,921,353.00	51,944,353.00
1.1.10.	Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	122,969,316.87	101,875,844.47
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1.	Үндсэн хөрөнгө	1,929,653,977.61	2,560,556,279.11
1.2.2.	Биет бус хөрөнгө	454,306.77	205,162.19
1.2.9.	Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн	1,930,108,284.38	2,560,761,441.30
1.3	Хөрөнгийн нийт дүн	2,053,077,601.25	2,662,637,285.77
2.	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1.	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1.	Дансны өглөг	23,209,082.75	14,098,608.75
2.1.1.3.	Татварын өр	9,798,872.23	15,941,464.62
2.1.1.4.	НДШ-ийн өглөг	-	12,949,380.45
2.1.1.12.	Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн	33,007,954.98	42,989,453.82
2.2	Өр төлбөрийн нийт дүн	33,007,954.98	42,989,453.826
2.3	Эздийн өмч	-	-
2.3.8.	Эздийн өмчийн бусад хэсэг	3,987,720,109.39	5,057,991,378.39
2.3.9.	Хуримтлагдсан ашиг	-1,967,650,463.12	-2,438,343,546.44
2.3.10.	Эздийн өмчийн нийт дүн	2,020,069,646.27	2,619,647,831.95
2.4	ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН	2,053,077,601.25	2,662,637,285.77

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1.	Татаас санхүүжилтийн орлого	845,830,200.00	1,100,000,000.00
2.	Борлуулалтын өртөг	-	-
3.	Нийт ашиг (алдагдал)	845,830,200.00	1,100,000,000.00
8.	Бусад орлого	24,868,500.00	3,134,993.59
9.	Борлуулалт, маркетингийн зардал	-	500,000.00
10.	Ерөнхий ба удирдлагын зардал	1,991,613,831.92	1,598,393,086.75
17.	Бусад ашиг (алдагдал)	-	18,544,658.00
18.	Татварын өмнөх ашиг (алдагдал)	-1,120,915,131.92	-477,213,435.16
19.	Орлогын татварын зардал	-	-
20.	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,120,915,131.92	-477,213,435.16
22.	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,120,915,131.92	-477,213,435.16
23.	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1.	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2.	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3.	Бусад олз (гарз)	-	-
24.	Орлогын нийт дүн	-1,120,915,131.92	-477,213,435.16
25.	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
	2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	3,987,720,109.39	-924,780,970.26	3,062,939,139.13
1.	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, алдааны залруулга	60,519,733.89	-	60,519,733.89
	Залруулсан үлдэгдэл	4,048,239,843.28	-924,780,970.26	3,123,458,873.02
2.	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-1,103,389,226.75	-1,103,389,226.75
	2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	4,048,239,843.28	-2,028,170,197.01	2,020,069,646.27
1.	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, алдааны залруулга	1,076,791,620.84	-	1,076,791,620.84
	Залруулсан үлдэгдэл	5,125,031,464.12	-2,028,170,197.01	3,096,861,267.11
2.	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-477,213,435.16	-477,213,435.16
	2024 оны 12 сарын 30-ны үлдэгдэл	5,125,031,464.12	-2,505,383,632.17	2,619,647,831.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1.	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-439,139.26	-2,904,456.45
1.1	Мөнгөн орлогын дүн	972,246,189.01	1,240,958,415.59
1.1.5.	Татаас, санхүүжилтийн орлого	845,830,200.00	1,100,000,000.00
1.1.6.	Бусад мөнгөн орлого	126,415,989.01	140,958,415.59
1.2	Мөнгөн зарлагын дүн	972,685,328.27	1,243,862,872.04
1.2.1.	Ажиллагчдад төлсөн	477,358,322.32	568,709,382.85
1.2.2.	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	66,636,847.94	147,624,539.36
1.2.3.	Бараа материал худалдан авахад төлсөн	11,581,450.00	60,956,416.00
1.2.4.	Ашиглалтын зардалд төлсөн	20,922,318.00	16,005,239.36
1.2.5.	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	262,602,321.00	183,036,230.00
1.2.7.	Татварын байгууллагад төлсөн	474,496.00	30,803,865.04
1.2.9.	Бусад мөнгөн зарлага	133,109,573.01	236,727,199.43
2.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,243,894.58	2,702,864.00
2.1	Мөнгөн орлогын дүн	1,436,428.58	2,702,864.00
2.1.5.	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,436,428.58	2,702,864.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	192,534.00	-
2.2.5.	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	192,534.00	-
4	БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	804,755.32	-201,592.45
5	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	416,755.55	1,221,510.87
6	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	1,221,510.87	1,019,918.42

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт				
2	Нийт орлого	-	1,121,679,651.59	-1,121,679,651.59	-
	Үүнээс:	-	1,121,679,651.59	-1,121,679,651.59	-
	а) Татаас санхүүжилтийн орлого	-	1,100,000,000.0	-1,100,000,000.0	-
	б) Бусад орлого	-	3,134,993.59	-3,134,993.59	-
	в) Бусад ашиг (алдагдал)	-	18,544,648.00	-18,544,648.00	-
3	Нийт зардал	-	1,598,893,086.75	-1,598,893,086.75	-
	Үүнээс:	-	1,598,893,086.75	-1,598,893,086.75	-
	а) Борлуулалт, маркетингийн зардал	-	500,000.00	-500,000.00	-
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	-	1,598,393,086.75	-1,598,393,086.75	-
4	Цэвэр ашиг, алдагдал	-	-477,213,435.16	477,213,435.16	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь "Цэвэр хотын өнгө үзэмж болон ногоон байгууламжийг бий болгож, иргэдэд эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх" гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон хог, хаягдлын үйлчилгээний үнэ тарифаар иргэн, аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллагад үйлчилгээ үзүүлэх, хог хаягдлыг тээвэрлэх, устгах боловсруулах ажил үйлчилгээ,
- Сумын өнгө үзэмжийг сайжруулах тохижилтын ажил үйлчилгээ эрхлэх,
- Сүхбаатар сумын нийтийн эзэмшлийн зам талбай, төв цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, ургалтыг хариуцан ажиллах,
- Үйлдвэрийн газрын захирлын тушаалаар тогтоосон үнэ тарифын модны болон цэцгийн үрслэгээний суулгацыг худалдах, мод, цэцэг тарих, суулгах,
- Сүхбаатар сумын ногоон байгууламжийн үйлчилгээний төлөвлөлт, бодлогыг боловсруулах, менежментийг сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхлэх,
- Ногоон байгууламж, байгаль орчны талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, хэтийн болон ойрын зорилтын дагуу сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлт тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05, 12 дугаар сарын 12-нд.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд Сүхбаатар сумын ИТХ, ЗДТГ, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч борлуулалтын орлого, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан *Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 609,559.7 мянган төгрөгөөр буюу 29.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,221.5	1,019.9	-201.6
Авлага	19,976.5	20,061.6	85.1
Бусад санхүүгийн хөрөнгө	28,850.0	28,850.0	0.0
Бараа материал	72,921.3	51,944.3	-20,977.0
Үндсэн хөрөнгө	1,929,654.0	2,560,556.3	630,902.3
Биет бус хөрөнгө	454.3	205.2	-249.1
Нийт хөрөнгө	2,053,077.6	2,662,637.3	609,559.7
Өр төлбөр	33,008.0	42,989.4	9,981.4
Эздийн өмчийн бусад хэсэг	3,987,720.1	5,057,991.4	1,070,271.3
Хуримтлагдсан ашиг	-1,967,650.5	-2,438,343.5	-470,693.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,053,077.6	2,662,637.3	609,559.7

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 20,061.6 мянган төгрөг болж 85.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны аудитаар өгөгдсөн актын төлбөр барагдаагүй тул авлагаар бүртгэснээс шалтгаалсан байна. Нийт авлагын 46.9 хувь буюу 9,415.9 мянган төгрөгийг 2012 онд үүсгэсэн айл өрх, аж ахуйн нэгжээс авах хогны төлбөрийн авлага эзэлж байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 51,944.3 мянган төгрөг болж 20,977.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын зарцуулалтаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,560,556.3 мянган төгрөг болж 630,902.3 мянган төгрөгөөр өссөн нь Сүхбаатар сумын хөрөнгө оруулалтаар 112,487.0 мянган төгрөгийн хог шахагч машин, 44,700.0 мянган төгрөгийн жижиг ковч хүлээн авсан болон 913,084.3 мянган төгрөгийн зам засвар, автомашины зогсоол зэргийг хөрөнгөд бүртгэснээс голлон шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 42,989.4 мянган төгрөг болж 9,981.4 мянган төгрөгөөр өссөн нь НДШ-ийн өглөгийн 12,949.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг боловсруулж, Сүхбаатар сумын ИТХ, Засаг даргаар батлуулаагүй байна.

Тайлант онд айл өрх, аж ахуйн хог хаягдлын хураамжийн орлогод 120,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 105,257.0 мянган төгрөг төвлөрүүлж 12.3 хувь буюу **14,743.0** мянган төгрөгөөр тасалсан байна.

Гүйцэтгэлээр Сүхбаатар сумын санхүүжилтээр 1,100,000.0 мянган төгрөг, ЗДНХ-өөс 1,500.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 20,179.7 мянган төгрөг зэрэг нийт **1,121,679.7** мянган төгрөг төвлөрүүлэн, **1,598,893.1** мянган төгрөгийн зардал гаргаж, **477,213.4** мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас */нийт элэгдэл 446,138.5/* голлон шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн бараа материалын бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дүгээр сарын 20-ний өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,991,613.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **13,941.3** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж бичиг хэргийн зардлыг хэмнэсэн,
- Ажилчдад олгодог нормын хувцаснаас өөрөөр байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан аваагүй,
- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй,
- Байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл, тавилга эд хогшил худалдаж аваагүй,
- Байгууллагын батлагдсан орон тоог хэмнэн ажилчид дотроосоо хавсран гүйцэтгүүлж ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 27 төрлийн 170 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Шууд худалдан авах болон харьцуулалтын аргын босго үнээс давсан 157,019.5 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бус шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д “... нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, Засгийн газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх:

“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар - Бараа 20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим, босго үнийн журмыг баримтлан зохион байгуулж байх **албан шаардлага** хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус байгууллагын худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 174 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 83.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	18,452.6	1	18,452.6	100.0
Зөвлөмж	5	9,415.9	4	9,415.9	80.0
Нийт дүн	6	27,868.5	5	27,868.5	83.3

Өмнөх аудитаар өгөгдсөн насжилт өндөртэй авлагын үлдэгдэлд дүн шинжилгээ хийж, авлагыг барагдуулах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагуудад хандаж шийдвэрлүүлэх, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **127,370.5** мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайланд 127,370.5 мянган төгрөгийн ажил гүйлгээний зардлын ангиллыг зөрүүтэй тайлагнасан байна. Үүнд:

- *Бараа материал худалдан авахад төлсөн 60,806.4 мянган төгрөгийн ажил гүйлгээг түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн зардалд,*

- *Бусад мөнгөн зарлагын 66,564.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн зардалд тус тус тайлагнасан.*

Аудитаар **92,386.3** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 63,536.3 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 28,850.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдөв.

5.1 Албан шаардлага

1. Тус газрын 2024 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь **“үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, **зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах**”** гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлагын хүрээнд захирлаар ажиллаж байсан Д.Ганцэцэгт холбогдох 2,115.6 мянган төгрөгийн, И.Чулуунболдод холбогдох 8,049.0 мянган төгрөгийн зэрэг нийт **10,164,6** мянган төгрөгийн төлбөрийг барагдуулахаар 2023 онд Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан боловч өнөөг хүртэл шийдвэрлүүлж, байгууллагыг хохиролгүй болгоогүй, авлагаар тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх **“Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана”**, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь **“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах....”**, гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгахаар өгсөн шийдвэрүүдийг хугацаанд нь биелүүлж, авлага барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэх.

3. Ажилчдын цалингаас суутгасан 5,644.1 мянган төгрөгийн НДШ-ийн, 6,142.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын зэрэг нийт **11,786.7** мянган төгрөгийг холбогдох дансад шилжүүлэлгүйгээр гудамж талбайн цэвэрлэгээ үйлчилгээний давс худалдан авахад зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх **“Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн **хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө**”**, ХХОАТ-ын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь **“Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд **дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ**”** гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын цалингаас хуулийн дагуу хийсэн суутгалуудыг тогтоосон хугацаанд холбогдох дансанд шилжүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

4. Анхан шатны бүрдэл дутуу дараах 41,585.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгасан. Үүнд:

- *Бараа материалын 25,385.0 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй,*
- *Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээнд бэлтгэн нийлүүлэх бараа материалын нэр, тоо ширхэг, үнэ, нийлүүлэх хугацаа, төлбөрийн нөхцөл, нийлүүлэгчийн гарын үсэг зэрэг үзүүлэлтийг тодорхой тусгаагүй, худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зэргээр анхан шатны бүрдэл дутуу баримтаар иргэн Ц.Болорзаяагаас 16,200.0 мянган төгрөгийн нормын хувцасны худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг цаасан болон цахим баримтаар баталгаажуулсны үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

2 Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Бусад байгууллагад шилжүүлэн ашиглагдаж буй боловч тус байгууллагын дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй 28,850.0 мянган төгрөгийн төмөр хашааг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар холбогдох байгууллагад хандаж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана”, 67 дугаар зүйлийн 67.2 дахь “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон

төлбөр тооцооны тооллого хийх, **үр дүнг шийдвэрлэх, ...**” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Уг хашааг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар холбогдох байгууллагад хандаж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд ажил гүйлгээний зардлын ангиллыг зөрүүтэй тайлагнасан	1	127,370.5			1	127,370.5	1	127,370.5				
Дүн	1	127,370.5			1	127,370.5	1	127,370.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй	1				1							
Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй буюу авлага барагдуулах арга хэмжээ аваагүй	1	10,164.6			1	10,164.6						
Ажилчдын цалингаас суутгасан суутгалыг шилжүүлэлгүйгээр зориулалт бусаар зарцуулсан	1	11,786.7			1	11,786.7						
Анхан шатны бүрдэл дутуу буюу хүчин төгөлдөр бус баримтаар зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан	1	41,585.0			1	41,585.0						
Тус байгууллагын эзэмшилд бүртгэлтэй боловч өөр байгууллагад ашиглагдаж буй хөрөнгийг шилжүүлж, данс бүртгэлээс хасаагүй	1	28,850.0					1	28,850.0				
Дүн	5	92,386.3			4	63,536.3	1	28,850.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТБОНӨХБАҮХАТухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Шууд худалдан авах болон харьцуулалтын аргын босго үнээс давсан шатахууны худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бус шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн.	1	157,019.5			1	157,019.5		
Дүн	1	157,019.5			1	157,019.5		